

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020.01.10

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь тус яамны 2019 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээний судалгааны ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх /Судалгаа болон үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байх (судалгааны хүрээлэн, төрийн бус байгууллага, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллага)/;

2. Байгууллагын танилцуулга ирүүлэх;

3. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх;

4. Сүүлийн 3 жил буюу 2017-2019 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй судалгаа, шинжилгээний ажлын жагсаалтыг хүснэгтээр ирүүлэх;

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт;

6. Татварын ерөнхий газрын [www.e-tax.mta.mn](http://www.e-tax.mta.mn) сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг ирүүлэх ба ингэхдээ хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлэх /Зөвлөх үйлчилгээ зарласан өдрөөс хойших байдлаар/;

7. Харьяа нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт ирүүлэх /Зөвлөх үйлчилгээ зарласан өдрөөс хойших байдлаар/;

8. Зөвлөхийн багт ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх CV-г ирүүлнэ.

Сонирхсон этгээд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 16.00 цагаас өмнө ирүүлнэ үү.

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ 16А,  
ЗАСГИЙН ГАЗРЫН 9А БАЙР, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ЯАМ, 404 ТООТ ӨРӨӨ